

Захиргааны хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд

2024 оны 02 сарын 27-ны

бүртгэлийн дугаарт бүртгэв.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 02 сарын  
08 -ны өдөр

Дугаар A/19/A/23

Улаанбаатар  
 хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Тушаалын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Төгөлдөр/, Мэдээллийн технологийн газар /С.Чинбат/-т үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга /Г.Цолмон/, Тагнуулын ерөнхий газрын Тамгын газрын дарга /Н.Бат-Очир/ нарт даалгасугай.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА

Н.ОДСНБААТАР

Бүртгэлийн дугаар: ..... 79 .....

УЛСЫН БҮРТГЭЛИЙН

ЕРӨНХИЙ ГАЗАР

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажлын газрын үсэг

.....

2024 оны 02 сарын 08-өдөр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга,  
Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны  
жаршилын төслийн өдрийн дугаар хамтартсан  
Улашаалын хавсралт

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ ҮЙЛДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
БОЛОН СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ  
ТАНИЛЦАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглахад энэ журмыг баримтална.

1.2. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Зөрчлийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулахад энэ журам хамаарахгүй.

Хоёр. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах

2.1. Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдийг бүртгэх тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарснаас хойш уг мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “Төрийн захиргааны байгууллага гэх”/-д 3 хоногийн дотор хүргүүлнэ.

2.2. Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/ сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах хүсэлтийг сонгуулийн санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагад бичгээр гаргана.

2.3. Төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.2-д заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш Эхонгийн дотор сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцуулах ажлыг зохион байгуулах өдрийг товлож, эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтын гарын үсэг

2024 он 07 сар 20 өдөр

2.4.Төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.3-т заасан үйл ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо, тагнуулын байгууллагын төлөөллийг оролцуулж хамтран зохион байгуулна.

2.5.Эрх бүхий этгээд сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахдаа төрийн захиргааны байгууллагын хамгаалалт хариуцсан цагдаагийн албан хаагчид биеийн байцаалтыг шалгуулж, нэвтрэнэ.

2.6.Эрх бүхий этгээд, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа, нэрийн жагсаалттай танилцахдаа хуульд заасан хүний хувийн мэдээллийг нууцлах, задруулахгүй байх үүргийг хүлээж, энэ журмын хавсралт “Баталгааны маягт”-ын дагуу баталгааг Төрийн захиргааны байгууллагын нууц хариуцсан ажилтанд бичгээр гаргана.

2.7.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцахад хүний хувийн мэдээллийг хамгаалах зорилгоор дараах үйлдлийг хориглоно:

2.7.1.дуу дүрсний бичлэг хийх зориулалт бүхий тоног, төхөөрөмж оруулах, ашиглах;

2.7.2.зураг авах, бичлэг хийх, шууд болон шууд бусаар дамжуулах зэргээр мэдээлэл тараах;

2.7.3.байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах, эмх замбараагүй байдал үүсгэх;

2.7.4.мэдээллийг хуульд зааснаас бусад хэлбэрээр авахыг шаардах, олж авсан мэдээллийг бусад зорилгоор ашиглах;

2.7.5.согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглээгүй байх,

2.7.6.хутга мэс, тэсэрч дэлбэрэх болон химиин шатамхай бодис оруулах, нэвтрүүлэх, ашиглах.

2.8.Төрийн захиргааны байгууллага доор дурдсан хүрээнд сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагааг танилцуулах ажлыг зохион байгуулна:

2.8.1.сонгуулийн хэсэг байгуулсан тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол хүлээн авч, сонгуулийн хэсэг байгуулах;

2.8.2.сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбар түүнд нэмэлт тэмдэглэгээ хийх;

2.8.3.сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах;

2.8.4.сонгогчийн бүртгэлийн программ хангамж;

2.8.5.сонгогчдын нэрийн жагсаалтад лавлагаагаар орсон өөрчлөлтийг тусгах.

Гурав.Сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглах

3.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай<sup>79</sup> хуулийн 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэгт заасан хугацаанд ээлжит сонгуульд оролцоо бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этээдийн гаргасан хүсэлтийн дагуу сонгогчдын

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

27.08.2015 сар 26.08.2016

нэрийн жагсаалтыг тоон гарын үсгээр баталгаажуулан, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу нууц баримт бичиг, нууц тээгчийг шилжүүлсэн тухай /Маягт-20/ тэмдэглэл үйлдэж олгоно.

3.2. Сонгогчдын нэрийн жагсаалт авах эрх бүхий этгээд нууц задруулахгүй байх баталгааг бичгээр гаргаж, албажуулах бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалт ашиглах үйл ажиллагаанд төрийн захиргааны байгууллага, тагнуулын байгууллага хяналт тавина.

3.3. Сонгогчдын нэрийн жагсаалтыг дараах зорилгоор ашиглуулна:

3.3.1. сонгогчдын нэрийн жагсаалтад давхардал байгаа эсэхийг нягтлан шалгах;

3.3.2. сонгуулийн эрх бүхий иргэн бүртгэгдсэн эсэх.

3.4. Сонгогчдын нэрийн жагсаалт авах эрх бүхий этгээд дараах үүргийг хүлээнэ:

3.4.1. сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэж, олшруулахгүй, тараахгүй байх;

3.4.2. сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахгүй, засварлахгүй;

3.4.3. цахим хуудас, мэдээллийн самбар зэрэг нийтийн бүх төрлийн мэдээллийн хэрэгсэлд байршуулахгүй байх;

3.4.4. хүний хувийн мэдээллийг нууцлах, задруулахгүй байх;

3.4.5 мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, үрэгдүүлэхгүй байх;

3.4.6. эрх бүхий этгээд сонгогчдын нэрийн жагсаалтыг ашигласан талаарх мэдээллийг төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх;

3.4.7. сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан эрх бүхий этгээд хуульд заасны дагуу олгосон сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн санал хураалт явагдаж дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;

3.4.8. сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ журамд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх;

3.4.9. хуульд заасан бусад.

Дөрөв. Бусад

4.1. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авах эрх бүхий этгээд, нууц хамгаалах ажилтан энэ журмын хавсралт "Сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцсэн тухай тэмдэглэл"-г үйлдэж, сонгогчдын нэрийн жагсаалт бүхий нууц тээгчийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүлээн авна.

4.2. Сонгогчдын нэрийн жагсаалт бүхий нууц тээгчийн бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтсэн, сонгогчдын нэрийн жагсаалтыг хууль бусаар хэвлэж тараасан гэх үндэслэл илэрсэн тохиолдолд нууц хамгаалах ажилтан тагнуулын байгууллагад даруй мэдээлнэ.

4.3. Нууц хамгаалах ажилтан хүлээн авсан сонгогчдын нэрийн жагсаалт бүхий нууц тээгчийг архивын хадгаламжийн нэгж үсгээн хадгална.

Тав. Хариуцлага  
Бүртгэлийн дугаар: .....

УЛСЫН ХАРГИДЫН

ЕРӨНХИЙ ГАЗАР


ХУУЛЬБАР ҮНЭН

Хуульбар олгосон ажилтны гарын үсэг

20.04.2018. өдөр

5.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

“Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам”-ын Хавсралт



## БАТАЛГААНЫ МАЯГТ

2024 оны...дугаар сарын  
....ны өдөр

Улаанбаатар  
хот

.....нам, эвсэл, эсхүл бие даан нэр дэвшигч, эсхүл төрийн бус байгууллагын төлөөллийн ..... албан тушаалтай

.....овогтой..... би Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг хууль, холбогдох журамд заасны дагуу танилцахдаа олж мэдсэн хуулиар тогтоосон нууцыг чанд хадгалж, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахаа баталж байна.

Хэрэв би төрийн болон албаны нууц, хүний хувийн нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг, үйл ажиллагааг задруулах, хувийн зорилгоор ашиглах, үрэгдүүлэх, бусдад дамжуулах зэрэг хууль бус үйлдэл гаргавал холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээхийг зөвшөөрч байна.

### БАТАЛГАА ГАРГАСАН:

.....албан тушаалтай.

.....овогтой.....

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

### БАТАЛГАА АВСАН:

Нууц хамгаалах ажилтан.....овогтой.....

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

Бүртгэлийн дугаар: .....79.....

УЛСЫН БҮРТГЭЛИЙН


ЕРӨНХИЙ ГАЗАР

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2024 он 02 сар 16 өдөр

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл  
ажиллагаа болон сонгогчдын нэрийн  
жагсаалттай танилцах, ашиглах  
журам"-ын Хавсралт



СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ БУЦААН  
ХҮЛЭЭЛЦСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны ...дугаар сарын  
....-ны өдөр

Улаанбаатар  
хот

.....нам, эвсэл.....  
/аль нь болохыг зурах/  
албан тушаалтай..... овогтой..... би  
Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн  
жагсаалтыг 20... оны .... дугаар сарын....-ны өдөр нягтлан шалгаж, хүлээлгэн өгч  
байна.

Сонгогчдын ..... нэрийн ..... жагсаалтын ..... файлын  
хэмжээ.....

.....

.....

.....

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН.  
НАМ/ЭВСЭЛИЙН..... АЛБАН ТУШААЛТАЙ  
..... ОВОГТОЙ .....

ХҮЛЭЭН АВСАН:

УБЕГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН  
ДАРГА

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА

НУУЦ ХАМГААЛАХ АЖИЛТАН

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
АЖИЛТАН

